

ЕБС-ИЙН СУРАЛЦАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

(11-р анги удирдсан багш нарт зориулсан сургалтын модуль)

С.Нямгэрэл (71 дүгээр сургуулийн сургалтын менежер)
nyam9923@gmail.mn

Сургалтын модулийн агуулга

- Сургалтын модулийн зорилго
- Сургалтын модуль хэрэгжүүлэх зөвлөмж
- АМЧБ олгох үйл ажиллагааны ангийн жилийн төлөвлөгөө /дадлага ажил /
- АМЧБ олгох үйл ажиллагааны сургуулийн жилийн төлөвлөгөө /дадлага ажил /
- Ашигласан ном зүй, цахим эх сурвалж

Зорилго:

11 дүгээр анги удирдсан багш нарт АМЧБО үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлэх, тэдний АМЧБ-ны талаарх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Модуль хэрэгжүүлэх зөвлөмж:

ЕБС-ийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжааг үр дүнтэй олгохын тулд анги удирдсан багшийн дэмжлэг чухал байдаг. Сургалтын чанарыг сайжруулах, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэхэд дэмжлэг үзүүлснээр сурагчид сурах үйл ажиллагаандаа хариуцлагатай хандах, мэдлэг, чадвараа нэмэгдүүлдэг.

Сурагчид эзэмшсэн чадвар, сурлагын амжилт, нийгмийн, сэтгэл хөдлөлийн болон биеийн хөгжлийн хурдаараа, түүнчлэн ажил мэргэжлийн сонголт, ямар хичээл, хөтөлбөр энэ ажил мэргэжлийг эзэмших боломж олгох вэ гэдэг ойлголтоороо харилцан адилгүй байдаг. Энэ ялгааг харгалзаж, хичээл сонголт хийх, ирээдүйг төсөөлөх мөрөөдлөө хэрэгжүүлэхэд, улмаар ажил мэргэжлийн олон боломж, хувилбаруудыг ойлгон, ухаалаг шийдвэр гаргахад туслах, бэлтгэх явдал багшийн нэг үүрэг юм.

Судалгаанаас харахад охид сонголтдоо хөвгүүдийг бодвол арай эрт хийж, түүндээ тууштай хандах хязгаарагдмал хандлага байдаг тул тэднийг нээлттэй, олон боломжийг мэдрүүлэх, зөв сонголт хийхэд нь дэмжих шаардлагатай.

Багш та ажил мэргэжлийн чиг баримжааны талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл дараах онолуудыг судалж үзээрэй. Үүнд:

- Онцлог шинж чанар болон хүчин зүйлийн онол
- Хөгжлийн онол
- Суралцахуй, танин мэдэхүйн онол
- Социологийн онол
- Психодинамик онол
- Хаосын онол

Онолыг илүү дэлгэрэнгүй www.myfuture.mn сайтаас танилцаж болно. Энэ ангийн сурагчид сонгон судлах хичээл, хөтөлбөр, МБС, их дээд сургууль болон хөдөлмөрийн зах зээлийн талаар илүү их мэдээлэлтэй байх тусам илүү идэвхтэй, эдийн засгийн хувьд тогтвортой байх нөхцөл бүрдэнэ. Анги удирдсан багш АМЧБО үйл ажиллагаагаар дамжуулан шийдвэр гаргах эгзэгтэй үед нь суралцагчдад дэмжлэг үзүүлэх, оновчтой сонголт хийх, дараагийн шатны сургалт болон ажил хөдөлмөрийн шилжилт амжилттай хийхэд нь бэлтгэх юм. АМЧБО үйл ажиллагааг явуулахын тулд 11 дүгээр ангийн олон бүлэгтэй сургууль бол бүлгүүдийн, цөөхөн

бүлэгтэй бол ахлах ангийн хамтарсан баг байгуулан хөтөлбөр боловсруулж ажиллах нь зүйтэй. Ингэхдээ орон нутгийн онцлог, нөөц бололцоогоо харгалзан үзэх хэрэгтэй. Тухайлбал төв суурин, Их дээд сургууль олонтой буюу огт байхгүй, ажлын байрны эрэлт, мэдээллийн эх сурвалжийг олж авах боломжоо тооцоолно. Багш танхимын болон танхимын бус үйл ажиллагааг явуулахдаа АМЧБО сурагчийн гарын авлагыг бусад эх сурвалжтай уялдуулан хэрэглээрэй. Сурагчийн гарын авлагыг ашиглахаас өмнө дасгал бүрт шаардлагатай өөрөөр хэлбэл тарааж өгөх материалыг бэлтгэх хэрэгтэй. Интернет, ном, гарын авлага, мэргэжлийн хүмүүс, ажлын байр гэх мэт бусад эх сурвалжийг ашиглах шаардлагатай. Сурагчдын гүйцэтгэх зарим дасгалыг гэрийн даалгавраар гүйцэтгүүлж болно. Аль ч ангийн хүүхэд ирээдүйгээ төсөөлөн төлөвлөх чадвартай байх ёстой. Ирээдүйн ажил мэргэжлээ таньж мэдэх, ямар чадвартай байх шаардлагатайг ойлгосноор сурах хандлага сайжирдаг. Тэдэнд сургалтын төрөл, олон боломж, төлөвлөлт, хүйсийн талаарх ойлголт, ажил хөдөлмөр амьдралын үндсэн үүрэгт хэрхэн нөлөөлдгийг мэдэх мэдлэг, чадваруудыг төлөвшүүлэх дасгал ажлуудыг гүйцэтгүүлэх нь үр дүнтэй. Багшийн үүргээс илүүтэйгээр харилцан ойлголцох, сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх, зөвлөхийн үүрэгтэй байхыг хичээгээрэй. Сурагчидтай ярилцах, тэднийг сайтар сонсох, асуудал юу байна, түүнийг хэрхэн шийдэх арга замуудыг хамтран шийдвэрлээрэй. Ахлах ангийн сурагчдад өөрөөр хэлбэл өсвөр насныханд тулгамдсан асуудлууд их, түүнийгээ илэрхийлж чадахгүй, дарамт шахалтанд орох магадлал өндөр байдаг тул тэдэнд туслах арга зам нь дасгал ажиллуулах, сонирхолтой ярилцлага хийх, урлан бүтээлгэх зэрэг аргаар ажиллах нь зүйтэй. Сурагчдад хаана ямар асуудал тулгарч буйг дасгал ажиллуулах замаар судалж болно. Үүнд:

- Сургуультай холбоотой асуудал
- Шийдвэр гаргахтай холбоотой асуудал
- Ажил хөдөлмөр, сургалтын байгууллагатай холбоотой асуудал гэж ялган ангилж, тандалт судалгаа хийнэ.

АУБ нар үйл ажиллагааг явуулахдаа анги хоорондын залгамж холбоог сайжруулан ажиллах хэрэгтэй. 10 дүгээр ангидаа хийж, төсөөлж, мөрөөдөж, сонгож байсан зүйлээ улам сайжруулан өөрчлөх, 11 дүгээр ангидаа нилээд судалгаатай, өөрийн итгэл үнэмшилтэй болох чадварыг эзэмшүүлнэ. Эцэг эхийн ажил мэргэжлийн чиг баримжааны талаарх ойлголтыг тандаж судалж, тэдний дэмжлэгтэйгээр үйл ажиллагааг явуулна.

Агуулга хэрэгжүүлэх сургалтын цагчилсан, төлөвлөгөө:

- Агуулгыг хичээлийн жилийн хугацаанд төлөвлөх хэрэгтэй. Үйл ажиллагааны чиглэл нь танхим ба танхимын бус хэлбэрээр явагдах нь үр дүнтэй.
- Ахлах анги тухайлбал 11 дугаар анги удирдсан багш нар хамтран ангийн түвшний хөтөлбөрийг боловсруулж болно. Гэхдээ багш та илүү бүтээлч чанараа хөтөлбөр боловсруулахад ашиглан ялгаатай, онцлог хийж болохыг анхаарч үзээрэй.

**Ангид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны
хөтөлбөрийн загвар**

БАТЛАВ.
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

**Сургуулийн ахлах ангийн сурагчдад АМЧБО үйл ажиллагааг
зохион байгуулах хөтөлбөр**

Үндэслэл: Яагаад тухайн сургууль ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх болсон шалтгаан, судалгаан дээр үндэслэсэн тоо баримт

Зорилго: Сургуулийн түвшний зорилго ерөнхий байж болно. Жишээ нь суралцагчийн сэдэл тэмүүллийг нэмэгдүүлэх, сурлагын амжилтыг сайжруулах, сургууль төрийн ба төрийн бус байгууллагуудын харилцаа холбоог нэмэгдүүлэх, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалт эсвэл хөдөлмөр эрхлэлтэд суралцагчдыг бэлтгэх гэх мэт ерөнхий зорилгыг дэвшүүлж болно.

Зорилт: Зорилгод хэрхэн хүрэхийг тодорхойлно. Жишээ нь суралцагчийн өөрийгөө таньж мэдэх талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, суралцагчийн ахлах ангийн хичээл болон ажил мэргэжлийн уялдаа холбооны талаарх ойлголтыг сайжруулах, суралцагчийн ирээдүйн төлөвлөлт хийх чадамжийг сайжруулах гэх мэт зорилгын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн, тодорхой байна.

Нөөц: сургуулийн дотоод ба гадаад нөөц бололцоо

Анги	Агуулга	Хэрэгжүүлэх хугацаа	Дуусах хугацаа	Хариуцах эзэн
11	10 дүгээр ангид сонгосон хичээлийг бататгах, түүнд дүгнэлт хийх	9-10 сар	нээлттэй	АУБ Нийгмийн ажилтан
	Ажил мэргэжлийн талаарх ойлголтыг сайжруулах сургалт зохион байгуулах	Улирал бүрд 2 цаг	I, II, III улирал	Сургалтын менежер
	Ажил хөдөлмөрийг хийж байгаа хүйсийн ялгааг ойлгох	III улирал	нээлттэй	АУБ
Үнэлгээ	Явцын Орцын Гарцын			Суралцагчдаас мөн эцэг эхийн асуулга судалгаа авч болно, Багш нар өөрийн үнэлгээ хийж болно.

Хөтөлбөрийн үнэлгээ: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаагаар суралцагчдын хүрсэн үр дүнгийн эцсийн үнэлгээг хийнэ.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажилгааны ангийн хөтөлбөр загвар

№	Үйл ажиллагааны чиглэл ба агуулга	Судлах цаг	тайлбар
1	10 дугаар ангидаа хийсэн сонголт, төлөвлөгөөгөө эргэж харах, сайжруулах - Ирээдүйгээ төлөвлөх, төсөөлөх - Сонголтоо өөрийн хүсэл, сонирхол, чадварт тулгуурлах - Ашиглаж буй мэдээлэл, эх сурвалж, материалд дүн шинжилгээ хийх - бусад	10	Хичээлийн жилийн эхэнд эцэг эхтэй нь хамтран хийх

2	<p>Дээд боловсрол, МБС, хөдөлмөрийн зах зээлийн сонголтоо хийх</p> <ul style="list-style-type: none"> - Ажил мэргэжлийн талаар судалгаа хийх - Сонгосон ажил мэргэжилтэй холбоотой боловсрол эзэмшиж болох төвийг судлах - Ажил мэргэжил, хичээл хоорондын холбоо уялдааг судлах - Ажил мэргэжил эзэмших олон янзын боломжууд болон сургалтыг судлах - Олон хувилбартай төлөвлөгөө зохиож судалгаа хийх - Бусад 	20	Их дээд сургууль болон МБС-тэй хамтрах
3	<p>Ажил мэргэжлийн сонголтын боломжоо анхааралтай үнэлж дүгнэх</p> <ul style="list-style-type: none"> - ажил хөдөлмөрт тохирсон эзэмшсэн чадвараа илрүүлэх - ажил хөдөлмөр эрхэлж буй хүйсийн онцлогийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөх - ирээдүйн ажил мэргэжил, амьдралын үүргээ ухамсарлах - бусад 	35	Мэргэжлийн багш нартай хамтрах
4	<p>Дээд боловсрол, МБС-ын талаар болон аль их сургуульд элсэх талаар түр хугацааны шийдвэр гаргах</p> <ul style="list-style-type: none"> - ажил мэргэжлийн талаарх мэдээллийг боловсруулах - мэдээлэл цуглуулж болхуйц цахим эх сурвалжуудыг ашиглаж сурах - их сургуулиудыг цахим эх сурвалжыг судлах - ажил мэргэжлийн талаарх мэдээлэлд үнэлт дүгнэлт хийх - хичээл сонголтоо хийх 	20	Эцэг эх болон их дээд сургууль, МБС-тэй хамтрах

Эзэмших мэдлэг, чадвар:

11 дүгээр ангийн сурагчдад АМЧБО үйл ажиллагаагаар дараах мэдлэг, чадварыг эзэмшүүлнэ.

ШИЙДВЭР ГАРГАХ ҮЕ	АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ	ЧАДАМЖ: ШААРДЛАГАТАЙ МЭДЛЭГ, ЧАДВАР
11 дүгээр анги	<ol style="list-style-type: none"> 1. 10 дугаар ангидаа хийсэн төлөвлөгөөгөө эргэж харах, сайжруулах 2. Дээд боловсрол, МБС, хөдөлмөрийн зах зээлийн сонголтоо хийх 3. Ажил мэргэжлийн сонголтын боломжоо анхааралтай үнэлж дүгнэх 4. Дээд боловсрол, МБС-ын талаар түр хугацааны шийдвэр гаргах 	<ul style="list-style-type: none"> ✓ Хөндлөнгийн нөлөөнд орж сонгосон хичээл, хөтөлбөрийг судалсны үр дагаврыг өөрт үр дүнтэй байдлаар ашиглах ✓ Хэрэв сонгон судлах хичээлээ өөрчлөх болбол 12 дугаар ангидаа амжилт гаргах боломжийг тооцоолох, энэ нь ажил мэргэжлийн сонголтод яаж нөлөөлөхийг ойлгох ✓ Сонирхож буй мэргэжилд өөрийн эзэмшсэн ямар чадвар давуу тал болох, ямар чадвар хөгжүүлэх шаардлагатайг тогтоох ✓ Ажил мэргэжилтэй холбоотой ямар төрлийн мэдээлэл хаанаас хайх, талаар судлах

	5. Аль их сургуульд элсэх талаар түр хугацааны шийдвэр гаргах	<ul style="list-style-type: none"> ✓ Ажил мэргэжлийн талаар хамгийн сүүлийн үеийн, найдвартай мэдээлэл хаанаас хайх, олж болох талаар мэдэх, тэмдэглэл хөтлөх ✓ Ажил мэргэжлийн ялгаатай боломжуудын талаар эргэцүүлэх, нээж илрүүлэх ✓ Сургалт болон ажил мэргэжлийн дунд, богино болон урт хугацааны төлөвлөгөө хийх, зорилго тодорхойлох, түүнийг хөгжүүлэх нарийн төлөвлөгөө хийх
--	---	--

Дараах дасгалууд АМЧБО үйл ажиллагаагаар эзэмшсэн байх мэдлэг чадварыг хөгжүүлэх зорилготой.

Анги	Мэдлэг	чадвар
11	Тодорхой ажил хөдөлмөр эрхлэхэд хэдэн төрлийн үүрэг гүйцэтгэх шаардлагатай байдаг, ажил хөдөлмөрийн бодит нөхцөл байдал ямар байдаг талаар мэдэх	Ажил олгогчид хүмүүсийг ажилд авахдаа ямар чанар, чадварт суурьладаг талаар мэдээлэл боловсруулах
	<p>Дасгал 1.</p> <p>Өдөр тутмын сонин сэтгүүл (ӨНӨӨДӨР, ӨДРИЙН СОНИН гэх мэт) эсвэл вэбсайт (http://biznetwork.mn http://hudulmur-halamj.gov.mn/job/list гэх мэт)-аас ямар нэг ажлын зар сонгуулах. Ажлын зарыг уншуулж, хүснэгт бөглүүлнэ. Янз бүрийн мэдээлэл, мэдлэг, ойлголт болон таамаглалаа ашиглан дэлгэрэнгүй бөглөх тал дээр багш зөвлөх.</p>	
	АЛБАН ТУШААЛ	
	ЦАЛИН	
	АЖИЛ ҮҮРЭГ (Ажлын зар дээр хийж гүйцэтгэх ажил үүргийг тодорхой тайлбарласан байдаг, Хэргээ тайлбар байхгүй бол холбогдох вэбсайтаас олж болно эсвэл тааж бичиж болно)	
	АЖЛЫН НӨХЦӨЛ (жишээ нь ажлын цаг, байршил, ажлын байрны нөхцөл, хөдөө орон нутагт ажиллах, томшилолтоор ажиллах тухай)	
	ХУВЬ ХҮҮНД ТАВИХ ШААРДЛАГА (жишээ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай хувь хүний зан чанар, чадвар гэх мэт)	
	БИЕИЙН ХҮЧНИЙ ШААРДЛАГА (жишээ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай биеийн хүчний чадвар гэх мэт)	
	ЭНЭ АЖЛЫГ ХИЙХЭД ШААРДАГДАХ МЭДЛЭГ, ЧАДВАР (тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, чадвар)	
БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ШААРДЛАГА (ЕБС, ахлах ангид судалсан байх ёстой хичээл, МБС, их, дээд сургууль гэх мэт)		
БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХУГАЦАА, АГУУЛГА		
СОНИН СЭТГҮҮЛ БОЛОН АЖЛЫН ЗАРЫН САЙТАД ЭНЭ ТӨРЛИЙН ХИЧНЭЭН АЖИЛ БАЙНА ВЭ?		

Ажил мэргэжил бүр өөр өөрийн онцлог чадвар шаардсан байдаг болон өөрийн сайн эзэмшсэн болон хөгжүүлэх шаардлагатай чадваруудыг мэдэх

Эзэмшсэн чадваруудаа мэдэх, зарим дутуу байгаа чадваруудаа нөхөх болон хөгжүүлэх

Дасгал 2.

Хувь хүний, практикийн болон хүмүүс хоорондын багц чадваруудаас сурагчын хэдийн

ХУВЬ ХҮНИЙ ЧАДВАР

Чадвар: Би...	Э	ХШ	Чадвар: Би...	Э	ХШ
Үнэнч шударга			Итгэл даасан		
Бусдаас хараат			Алиа хошин		
Сүрэх хүсэл эрмэлзэлтэй			Нөхөрсөг, нийтэч		
Өөртөө итгэлтэй			Эмх цэгцтэй		
Зорилготой			Алдаагаа хүлээн зөвшөөрдөг		
Бүтээлч			Шүүмжлэлийг хүлээн авдаг		
Урам зориг дүүрэн, идэвхтэй			Өөрийгөө чөлөөтэй илэрхийлдэг		
Асуудал шийдэгч			Багийн тоглогч		
Нягт нямбай, цаг баримталдаг			Бие даасан		
Практикийн			Эерэг		
Эелдэг			Тайван		
Дасан зохицохдоо сайн			Аналитик		
Амбицтай, өсөж хөгжих дуртай			Нүүрэмгий		

Дээрх чадвараас хамгийн сайн "ХУВЬ ХҮНИЙ ЧАДВАР"-аа сонгож, эрэмбэлнэ үү! (хамгийн сайн гэх мэт доошоо эрэмбэлнэ):

1.	4.
2.	5.
3.	

эзэмшсэн байгаа чадвар болон хөгжүүлэх шаардлагатай чадварыг тэмдэглүүлж, хамгийн сайн 5 чадварыг эрэмблүүлэх.

ХҮМҮҮС ХООРОНДЫН БОЛОН БАГААР АЖИЛЛАХ ЧАДВАР

Чадвар: Би ... чадна	Э	ХШ	Чадвар: Би ... чадна	Э	ХШ
Бусадтай сайн ажиллах			Танихгүй хүнтэй уулзах, мэндлэх		
Сайн харилцах			Бусдын санал бодлыг асууж, таньж мэдэх		
Бусдыг удирдах, манлайлах			Бусад хүмүүс сонсож байгаа эсэхэд хяналт тавих, анхаарал хандуулах		
Хурал уулзалт удирдах			Бүлгийн өмнө ярих		
Бусдад удирдуулах			Бусдын санааг дагах		
Ямар нэг зөрчлийг шийдвэрлэх			Бусдыг хөхүүлэн дэмжих		
Бусдыг сонсох			Удирдах эсвэл эрх мэдэл бүхий албан тушаалын хүнтэй сайн хамтарч ажиллах		

Дээрх чадвараас хамгийн сайн "ХҮМҮҮС ХООРОНДЫН БОЛОН БАГААР АЖИЛЛАХ ЧАДВАР"-аа сонгож, эрэмбэлнэ үү! (1 хамгийн сайн гэх мэт доошоо эрэмбэлнэ):

1.	4.
2.	5.
3.	

Сонгосон мэргэжлийн үндсэн ажил үүрэг юу болох, энэ ажил мэргэжилтэй хамгийн сайн уялдах хичээлүүд, ямар их, дээд сургууль эсвэл МБС-д суралцах шаардлагатай тухай, сургалтын хугацаа, төлбөр болон бусад зардал, яагаад энэ ажил мэргэжлийг сонирхож байгаа шалтгааныг нарийвчлан мэдэх

Сонгосон ажил мэргэжилтэй болохын тулд одооноос юу хийх ёстой талаар интернет эх сурвалж, ном гарын авлага ашиглан судалгаа хийх

Дасгал 3.

Сонгосон 5 ажил мэргэжлийн дагуу нарийвчлан судалгаа хийх. Дасгалуудыг ажиллахдаа интернет эх сурвалж, ном гарын авлага ашиглах эсвэл ангийнхаа хүүхдүүдтэй зөвлөлдөж болно.

1. Албан тушаалын нэр

2. Үндсэн ажил үүргийг товч тайлбарлан бичнэ үү

3. Энэ ажил мэргэжлийг эзэмшихэд ахлах ангид ямар хичээл сонгон судлах хэрэгтэй вэ?

4. Энэ ажил мэргэжилтэй болохын тулд ямар их, дээд сургууль эсвэл МБС-ын байгууллагад сурах хэрэгтэй вэ? 2-3 их, дээд сургууль эсвэл МБС-ын байгууллагыг бичнэ үү!

1. ...

2. ...

3. ...

5. Сургалтын хугацаа ямар байх вэ?

|

6. Сургалтын зардал ямар байх вэ?

7. Энэ ажил мэргэжил яагаад таны чадвар, оюун ухааны хэв шинжтэй тохирно гэж бодож байна вэ?

8. Энэ ажил мэргэжилтэй болоход дараах 3 алхам их чухал юм. Энд тухайн ажил мэргэжилтэй холбоотой ахлах ангид ямар хичээл сонгох, элсэлтийн шалгалтаа ямар хичээлээр өгөх, хэдэн оноо авах, өөрийгөө хэрхэн бэлтгэх гэх мэт үйл ажиллагааны алхмуудын бичиж болно.

i)

ii)

iii)

<p>Ажил мэргэжлийн төлөвлөгөө хийхэд ашиглах эх сурвалжийн талаар судалгаа хийх, түүнийг ашиглах, энэ төлөвлөгөө хийх мэдээллийг илүү системтэйгээр боловсруулах бүрэн мэдээлэл авах талаар мэдэх</p>	<p>Ажил мэргэжлийн төлөвлөгөө хийхтэй холбоотой мэдээллийг үнэлэх чадварт суралцах</p>
--	---

Дасгал 4. Ажил мэргэжлийн төлөвлөгөө хийхэд ашиглах интернетийн эх сурвалжийн талаар судалгаа хийх.

1. Төрийн өмчийн МБС-ын байгууллага, сургуулиуд, түүнд элсэн суралцахтай холбоотой мэдээлэл бүхий ном, гарын авлагыг жагсаан бичнэ үү!
 - i.
 - ii.
 - iii.
 - iv. ... гэх мэт
2. Хувийн МБС-ын байгууллага, сургуулиуд, түүнд элсэн суралцахтай холбоотой мэдээлэл бүхий ном, гарын авлагыг жагсаан бичнэ үү!
 - i.
 - ii.
 - iii.
 - iv. ... гэх мэт
3. Төрийн өмчийн их дээд сургуулиуд, түүнд элсэн суралцахтай холбоотой мэдээлэл бүхий ном, гарын авлагыг жагсаан бичнэ үү!
 - i.
 - ii.
 - iii.
 - iv. ... гэх мэт
4. Хувийн их дээд сургуулиуд, түүнд элсэн суралцахтай холбоотой мэдээлэл бүхий ном, гарын авлагыг жагсаан бичнэ үү!
 - i.
 - ii.
 - iii.
 - iv. ... гэх мэт
5. Их, дээд сургууль, МБС-ын байгууллагад суралцах тэтгэлэг болон санхүүгийн дэмжлэгийн талаарх мэдээлэл бүхий ном, гарын авлагыг жагсаан бичнэ үү!
 - i.
 - ii.
 - iii.
 - iv. ... гэх мэт
6. Тодорхой ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн ажил үүрэг болон тэдгээрт тавигдах шаардлагын талаарх мэдээлэл бүхий ном, гарын авлагыг жагсаан бичнэ үү!
 - i.
 - ii.
 - iii.
 - iv. ... гэх мэт

Арга зүй:

Сургуульд суурилсан арга:

Сургуулийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга замаар АМЧБО үйл ажиллагааг цогц, чанартай, уялдаа холбоотой явуулж болно.

Ангид суурилсан арга:

Анги удирдсан багш та сургуулийнхаа хөтөлбөрөөс тухайн ангийнхаа хөтөлбөрийг боловсруулан ажиллана. 11 дүгээр ангийн хувьд сурагчдын дараах чадваруудыг хөгжүүлэх арга зүйг ашиглах нь зүйтэй.

- хичээл болон суралцагчдын сонирхож буй ажил мэргэжил, боловсрол, сургалтын боломжуудын хоорондын уялдааг таньж мэдэхэд дэмжлэг үзүүлэх
 - o Багаар ажиллах
 - o Хосоор ажиллах
 - o Сорил даалгавар

- Судалгаа хийх
- Харилцан ярилцах
- ажил мэргэжлийн болон сургалтын олон янзын боломжийн талаар эргэцүүлэхэд чиглүүлэх
 - судалгааны арга
 - Тэмдэглэл хөтлөх
 - Төлөвлөгөө гаргах
 - Сорил даалгавар ажиллах
 - уулзалт зохион байгуулах
 - илтгэл, эссэ бичих, унших
 - хэлэлцүүлэг хийх
- Их, дээд сургууль болон МБС-ын ажил мэргэжлийн сонголт хийх, тэдгээрийн харилцаа холбоо хамтын ажиллагааг судалж дэмжлэг үзүүлэх
 - дүрийн тоглолт
 - зочин хичээл
 - зурагт мэдээлэл бэлтгэх
 - мэргэжил бүхэн сайхан өдөрлөг
 - сүлжээний арга
 - танилцах аялал
 - инсертийн арга

Хавсралт 1.

11 дүгээр ангийн “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” жилийн үйл ажиллагааны төлөвлөлт

Сэдэв: Ажил мэргэжлийн чиг баримжаа

Зорилго: Суралцагч нь амьдралын бодит асуудлыг олж, шийдвэрлэх явцдаа судлан шинжлэх арга барилд суралцаж бусадтай харилцаа холбоо тогтоон хамтран ажиллаж, өөрийн амьдрах арга ухаан, суралцах арга барилаа эрэгцүүлэн бодож улам сайжруулан түүнийгээ хэрэгжүүлэх замаар суралцах хүсэл эрмэлзэлтэй амьдрах чадвартай иргэн болгож төлөвшүүлнэ.

Зорилт ба хүрэх үр дүн

- Амьдралын бодит асуудлыг ажиглах, эрж хайх, олох, энэ талаар мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээллээ эмхэлж цэгцлэх, задлан шинжлэл хийж нэгтгэн дүгнэх, оновчтой ойлгомжтой илэрхийлэх, шийдвэрлэх замаар суралцах чадвартай болно.
- Бусадтай санал бодлоо хуваалцах, үр дүнтэй харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах чадвараа хөгжүүлнэ.
- Өөрийн амьдрах арга ухаан, сурах арга барилаа эргэцүүлэн бодож, сайжруулах арга замаа тодорхойлон хэрэгжүүлж асуудлаа шийдвэрлэж чаддаг амьдрах чадвартай иргэн болгоно.
- Сурах хүсэл эрмэлзлэл, сонирхол идэвх зүтгэлтэй болгоно.

Нийт цаг: 23

Эзэмших чадварууд:

- Эх сурвалж ашиглан мэдээлэл цуглуулах.
- Эрэгцүүлэн бодох.
- Мэдээлэл цуглуулах, боловсруулах чадвар
- Мэдээллээ ялгах, ангилах, эрэмбэлэх, харьцуулах, задлан шинжлэх чадвар
- Бусдыг сонсох, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх

Агуулгын хүрээ

№	Чадамж	Агуулга	Цаг	Арга зүй	Хэрэглэгдэхүүн	Үнэлгээ
1	Суралцагчид өөрсдийн хувь хүний, практикийн болон хүмүүс хоорондын чадвараа үнэлэж, дүгнэнэ.	Ажлын шаардлага	2	Хосоор, асуулга Ярилцлага Бод, хамтар, хуваалц	Өдөр тутмын сонин болон вэбсайтад гарсан ажлын зарын хуулбар болон Суралцагчийн гарын авлагын хуудас	Суралцагчид ажил хөдөлмөр болон сургалтын боломжийн уялдааг таньж мэдэх, түүнчлэн ажлын бусад шаардлагатай танилцсан эсэхийг багш сонсож ажиглалтын судалгаа хийх Суралцагчид хувь хүний, практикийн болон хүмүүс хоорондын чадвараа таньж мэдэх
		Чадвартаа дүн шинжилгээ хийх	2			
	Суралцагчид ажлын шаардлага, энэ ажилтай холбоотой их, дээд сургууль, МБС-ын байгууллагын боломжийн талаар судалгаа хийнэ.	Миний ур чадвар	3	Бод хамтар хуваалц	Гарын авлагын хуудас	Суралцагчид өөрт байгаа олон янзын ур чадвараа илрүүлж, тэдгээрийн давуу талыг тодорхойлж, түүнийгээ янз бүрийн ажилтай уялдуулж чаддаг болно. Эндээс юу сурав, өмнө ажилласан “Ажлын шаардлага” дасгал хэрэгтэй байна уу гэдгийг ярилцана. Багш энэ үед зүгээр л сонсох бөгөөд ямар нэг үнэлэлт дүгнэлт өгөх хэрэггүй. Суралцагчид өөрсдийн ур чадвараа нэгтгэн дүгнэж, ажилтай уялдуулна.
		Ажил мэргэжлийн төлөвлөлтийн хураангуй	2	KWL арга Багаар		
		Хамгийн ихээр сонирхож буй 5 ажил	2	Хосоор		
		Ажил мэргэжлийн төлөвлөгөөний үргэлжлэл	5	Асуулгын хуудас Ярилцлага		

Суралцагчид интернет болон ном гарын авлагын эх сурвалжаа үнэлж сурна.	АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ ИНТЕРНЕТИЙН ЭХ СУРВАЛЖ – ЭХНИЙ ХЭСЭГ	2	KWL арга	Гарын авлагын хуудас	Суралцагчид өөрсдийн ур чадвараа нэгтгэн дүгнэж, ажилтай уялдуулна.
	АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ ИНТЕРНЕТИЙН ЭХ СУРВАЛЖ – ХОЁР ДАХЬ ХЭСЭГ	2			
	АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ НОМ, ГАРЫН АВЛАГА – ЭХНИЙ ХЭСЭГ	2			
	АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ НОМ, ГАРЫН АВЛАГА – ХОЁР ДАХЬ ХЭСЭГ	1			

1 дүгээр баг

Вэбсайтын нэр	Хамгийн хэрэгтэй байсан зүйл	Сул тал	Бусад шүүмжлэлт санал

2 дугаар баг

Ном, гарын авлагын нэр	Хамгийн хэрэгтэй байсан зүйл	Сул тал	Бусад шүүмжлэлт санал

Мэдлэг, чадвар үнэлэх:

11 дүгээр ангийн сурагчдын АМЧБО үйл ажиллагаагаар эзэмшигдсэн байх мэдлэг, чадварыг үнэлэх, дүгнэх, тандалт судалгаа хийх нь багшийн үндсэн ажлын нэг хэсэг юм. Анги удирдсан багшийн хувьд сурагчдад гарч буй хандлага, өөрчлөлтийг ажиглаж мэдэхээс гадна янз бүрийн тухайлбал өөрөө өөрийгөө үнэлэх, эцэг эхтэйгээ хамтран хийж болох дасгал, сорилын тест, явцын болон гарцын асуулга боловсруулж, ярилцлагыг хийж болно.

Жишиг даалгавар:

Сурагчдыг хэд хэдэн баг болгон ажил мэргэжлийн болон хөдөлмөр эрхлэлтийн талаар ямар мэдээлэлтэй, хир ойлголттой байгааг тандан судлах зорилгоор дараах дасгалыг гүйцэтгүүлж болно. Энэ дасгалыг хичээлийн жилийн эхэнд мөн төгсгөлд давтан хийлгүүлж, гарч буй өөрчлөлтийг ажиглана. Бие даан судалгаа хийж байгаа хандлагын өөрчлөлт ажиглагдана.

- ашигласан эх сурвалж материалуудын жагсаалт гаргаж, эдгээрээс хамгийн хэрэгтэй эх сурвалж, төдийлөн хэрэггүй эх сурвалж, хэрэггүй эх сурвалжийн хувьд ямар мэдээлэл дутуу байсан, ямар сул тал байсан зэргийг үнэлэх

Ашиглах ном зүй:

АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан

- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн сурагчийн дасгал ажлын ном/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн багшийн гарын авлага/ 2018
- Ажил мэргэжлээ сонгох нь /ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сонирхол, чадвар болон үнэт зүйлээ тодорхойлох, тохирох ажил мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх сорил/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг төлөвлөх нь /Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага/ 2018
- Сургуулийн удирдлагын гарын авлага, АХБ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ УЛААНБААТАР 2016
- Багшийн гарын авлага, АХБ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ УЛААНБААТАР 2016

Цахим эх сурвалж:

www.myfuture.mn

<https://mergejil.mn>

<http://num.edu.mn>

<http://msue.edu.mn>

<http://rilsp.gov.mn>

<https://www.careers.govt.nz/jobs-database/>

<https://nationalcareersservice.direct.gov.uk/job-profiles/home>

<https://www.onetonline.org/find/family>

<http://hudulmur-halamj.gov.mn/occ>

<http://jobclass.ubstat.mn/>

“Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох “Чанартай боловсрол”-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ. Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Түүнчлэн мэргэжил сонголтод жендерийн талаарх хэвшмэл хандлагаас сэргийлэн хичээл, үйл ажиллагааг мэдрэмжтэй удирдан зохион байгуулж охид, хөвгүүдийн боломж ижил тэнцүү байдаг талаас нь ойлгуулна. Түгээмэл биш ажил мэргэжлийн талаар ярилцахдаа илүү мэдрэмжтэй байж охид, хөвгүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах, суралцагчдад аль болох олон төрлийн ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

